



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/552

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн хуучин барилгын суурийг нурааж цэвэрлэх үйл ажиллагаанд зарцуулагдах 12,000,000 (Арван хоёр сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх 12,000,000 (Арван хоёр сая) төгрөгийг Эрх зүйн нийгмийн хэв журам хөтөлбөрийн Засаг даргад хуулиар олгогдсон үүрэг эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ